

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/65/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүү аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер А.Цогбаяр
Утас: 260512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Ариунжаргал
Утас: Цахим хаяг ariunjargalb@audit.gov.mn
Цэгцтөв богд аудит ХХК-ийн захирал Н.Цэрэнханд
Утас: 99901517 Цахим хаяг: tsegtstuvbogd@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ , түүний үйл ажиллагаа	9
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж:.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

“ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН
ТҮНШЛЭЛИЙН ТӨВ” ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ М.АМГАЛАНБААТАР ТАНАА

2026. 03. 16 № 06/668
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 91.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 16.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлд тооллого хийгдээгүй;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар тайлант оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг батлуулаагүй, өмнөх оны цэвэр ашгийн дүнгээс тооцсон 57.9 сая төгрөгийн ноогдол ашгийг хуулийн дагуу тохиролцон тогтоогоогүй, татаас санхүүжилтийн үлдэгдэл 45.7 сая төгрөгийг улсын төсөвт буцааж төвлөрүүлсэн зэргээс шалтгаалан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 312 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх боломжгүй болсон;
- Эрх бүхий албан тушаалтны баталсан зардлын хэмжээг баримтлаагүй 8.6 сая төгрөгөөр гадаад албан томилолтын зардлыг илүү олгосон, томилолтын зардлын 4.3 сая төгрөгийг цалингийн зардалд тайлагнасан;
- Авто зогсоолын төлбөрт 4.2 сая төгрөг төлж төсвийг үрэлгэн зарцуулсан зэрэг зөрчлүүд илэрсэн;

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 72 дугаар зүйлийн 4/4 дэх, 73 дугаар зүйлийн 2 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “нийцсэн ба зохистой байх, “ангилал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 41, 749 дугаар тогтоолуудаар “Санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ-аас 11.9 сая төгрөг, Эдийн засаг хөгжлийн яамнаас 101.8 сая төгрөг, нийт 113.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй авч данс бүртгэлд тусгажээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант хугацаанд “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ нь Эдийн засаг хөгжлийн яамнаас 2,228.0 сая төгрөгийн татаас санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 5.7 сая төгрөг, арилжааны банкгаас хүүгийн орлогоор 11.8 сая төгрөг, бусад орлогоор 3.9 сая төгрөг, нийт 2,249.4 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд 1,741.2 сая төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй 508.2 сая төгрөгийг мөнгөн хөрөнгийн дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Бусад асуудал

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ нь эрх бүхий байгууллагаас түншлэлээр хэрэгжүүлэхээр ирүүлсэн 6 төслийн материалд урьдчилсан үнэлгээ, ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Байдрагын УЦС төслийн бүрэн шинжилгээ хийж хүргүүлжээ.

Мөрөн-Улиастай чиглэлийн 261.89 км хатуу хучилттай автозамын төслийн бүрэн шинжилгээ хийж, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамнаас зөвшөөрөл авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, Засгийн газрын 2025 оны 60 дугаар тогтоолоор түншлэлээр хэрэгжүүлэх шийдвэр гарчээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В.А.М.* Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	196,119.84	508,403,217.08
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	17,411.44	-
1.1.4	Бусад авлага	75,962.00	736,356.85
1.1.6	Бараа материал	9,897,493.00	16,803,440.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	260,706.94	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	10,447,693.22	525,943,013.93
1.2.1	Үндсэн хөрөнгө	101,426,623.29	199,954,152.29
1.2.2	Биет бус хөрөнгө	17,591,400.00	18,695,300.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	119,018,023.29	218,649,452.29
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	129,465,716.51	744,592,466.22
2.1.1.1	Дансны өглөг	-	1,535,000.00
2.1.1.3	Татварын өр	13,627,764.60	13,477,623.71
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	346,115.16
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	10,000.00	99,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	13,637,764.60	15,457,738.87
2.2	Өр төлбөрийн нийт дүн	13,637,764.60	15,457,738.87
2.3.9	Хуримтлагдсан ашиг	115,827,951.91	729,134,727.35
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	115,827,951.91	729,134,727.35
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	129,465,716.51	744,592,466.22

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	5,720,000.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	
3	Нийт ашиг (алдагдал)	-	5,720,000.00
5	Хүүний орлого	316,272.97	11,819,241.69
8	Бусад орлого	556,253,500.00	2,314,662,216.68
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	382,149,755.79	1,716,035,143.73
11	Санхүүгийн зардал	21,200.00	
12	Бусад зардал	45,701,092.83	1,106,615.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	128,697,724.35	615,060,699.64
19	Орлогын татварын зардал	12,869,772.44	1,753,924.20
20	Татварын дараах ашиг (алдагдал)	115,827,951.91	613,306,775.44
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	115,827,951.91	613,306,775.44
27	Орлогын нийт дүн	115,827,951.91	613,306,775.44

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	115,827,951.91	115,827,951.91
2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	-	-	115,827,951.91	115,827,951.91
Залруулсан үлдэгдэл	-	-	115,827,951.91	115,827,951.91
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	613,306,775.44	613,306,775.44
2025 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	-	-	729,134,727.35	729,134,727.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	557,493,968.17	2,237,608,970.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	5,720,000.00
	Татаас, санхүүжилтын орлого	556,253,500.00	2,227,981,700.00
	Бусад мөнгөн орлого	1,240,468.17	3,907,270.00
1.2	Мөнгөн зарлага (-)	443,017,681.33	1,693,379,814.45
	Ажиллагчдад төлсөн	126,638,899.00	835,557,555.98
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	38,707,668.00	247,149,756.78
	Бараа материал худалдан авахад төлсөн	50,324,869.00	2,077,500.00
	Ашиглалтын зардалд төлсөн	7,000,000.00	42,000,000.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,000,000.00	200,000.00
	Татварын байгууллагад төлсөн	13,172,011.30	90,858,427.98
	Бусад мөнгөн зарлага	204,174,234.03	475,536,573.71
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	114,476,286.84	544,229,155.55
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		11,819,241.69
	Хүлээн авсан хүүний орлого		11,819,241.69
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		47,841,300.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд	114,280,167.00	31,084,800.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд	-	16,756,500.00
2.3	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(114,280,167.00)	(36,022,058.31)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	196,119.84	508,207,097.24
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	196,119.84
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	196,119.84	508,403,217.08

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:			-	-	-	-	-	-	-
	Хүүгийн орлого	м.төг	316.3		11,819.2	11,502.9	3,736.7	(11,819.2)	
	Бусад орлого	м.төг			5,720.0	5,720.0		(5,720.0)	
	Үнэ төлбөргүй хүлээж авсан /үндсэн хөрөнгө/	м.төг			86,680.5	86,680.5		(86,680.5)	
	Татаас санхүүжилтын орлого	м.төг	556,253.5	4,772,956.8	2,227,981.7	1,617,728.2	400.5	2,544,975.1	46.7
2	Нийт орлого	м.төг	556,569.8	4,772,956.8	2,332,201.4	1,775,631.6	419.0	2,440,755.4	48.9
3	Нийт зардал	м.төг	427,872.1	4,772,956.8	1,717,140.7	1,289,268.6	401.3	3,055,816.1	36.0
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	382,149.8	1,749,510.0	1,716,034.1	1,333,884.3	449.0	32,369.3	98.1
4	Татварын өмнөх ашиг	м.төг	128,697.7	-	615,060.7	486,363.0	477.9	615,060.7	
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	115,827.9	-	613,306.8	497,478.9	529.5	(613,306.8)	
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	64,749.5	338,703.0	337,576.1	272,826.6	521.4	1,126.9	99.7
	а/ Орлогын татварт	м.төг	12,869.8	-	1,753.9	(11,115.9)	13.6	(1,753.9)	
	в/ НДШ	м.төг	38,707.7	249,120.0	246,867.8	208,160.1	637.8	2,252.2	99.1
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	13,172.0	89,583.0	88,954.4	75,782.4	675.3	628.6	
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	23.0	25.0	23.0	-	100.0	2.0	92.0
9	Нийт цалингийн сан	м.төг	161,281.9	1,038,000.0	1,028,721.3	867,439.4	637.8	9,278.7	99.1
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	3,506.1	3,460.0	3,727.3	221.1	106.3	(267.3)	107.7
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.7	1.0	0.7	(0.0)	100.0	0.3	73.6
12	Хөрөнгө оруулалт	м.төг	114,280.2	37,385.0	33,583.8	(80,696.4)	29.4	3,801.2	89.8
13	Нийт авлага	м.төг	-	-	736.5	736.5		(736.5)	
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-		-	
14	Нийт өглөг	м.төг	13,627.8	-	15,457.7	1,829.9	113.4	(15,457.7)	
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	13,627.8	-	15,457.7	1,829.9	113.4	(15,457.7)	
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	-	-	-	-		-	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ , түүний үйл ажиллагаа

Засгийн газрын 2024 оны 23 дугаар тогтоолоор ЭЗХЯ-ны харьяанд “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-ыг байгуулж, дүрмийг баталжээ.

Тус газар нь эрхэм зорилгоо “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн үр ашигтай менежментийг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын шинэ эх үүсвэрээр Монгол улсын дэд бүтцийн болон төрийн үйлчилгээний салбарыг хөгжүүлнэ” гэж тодорхойлсон байна.

“Төр хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.5-д заасан түншлэлийн гарын авлагыг боловсруулах, шинэчлэх, төрийн болон хувийн хэвшлийн түншлэгч байгууллагууд, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, түншлэлийн талаарх ойлголтыг сурталчлан таниулж, мэдээлэх, шаардлагатай сургалт, семинарыг зохион байгуулах үйл ажиллагаа явуулдаг, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа явуулсан байна. Тухайлбал:

- Түншлэлийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төр болон хувийн хэвшил хоорондын үр дүнтэй, тогтвортой түншлэлийг хэрэгжүүлж, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ, техник эдийн засгийн үндэслэл, эрсдлийн шинжилгээ, үнэлгээг төрийн түншлэгч болон мэргэжлийн зөвлөх, төслийн багтай хамтран боловсруулах;
- Судалгаа, шинжилгээний үр дүнг салбарын болон түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж, төслийг үнэлж, түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромтой эсэхийг шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллээр хангах;
- Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцоход санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;
- Төслийн хэрэгжилтийн санхүүгийн болон эрсдлийн хяналт шинжилгээг тайлагнах;
- Түншлэлийн төсөлд шаардлагатай мэдээлэл, журам, сонгон шалгаруулалтад бүрдүүлэх баримт бичиг, зааварчилгаа, маягт, түншлэлийн жишиг гэрээний загвар, түншлэлд оролцогч этгээдэд шаардлагатай холбогдох баримт бичгийг боловсруулах, мэдээллийг түншлэлийн мэдээллийн нэгдсэн санд тогтмол байршуулах, олон нийтэд ил тод, хүртээмжтэй хүргэх;

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ нь Компанийн тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Татварын хуулиуд зэрэг хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд ТӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.24, 7.2.7, 8.1.1, 8.1.3, 8.1.16, 8.2, 9.1.4, 9.1.5, 9.1.8, 11.2.2, 12.2.2, 12.2.3, 13.2, 13.4, 17.1.26, 18.1, 18.2, 18.2.1, 18.2.15, 18.4, 20.2, 20.4.2, 20.11, 21.5.1, 21.6, 21.7, 22.1, 25 дугаар зүйл, 26.1, 26.2, 26.4, 26.5, 39.1, 39.1.2, 39.1.2, 39.3, 43.8, 56.4 дахь заалтууд;
- Хувь хүний орлогын албан татварын хуулийн 12.1.2, 19.1.2 дэхь заалт;

“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Тус түншлэлийн төв нь дотоод хяналт хариуцсан ажилтангүй тул дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус ТӨААТҮГ-т мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэжээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 615.1 сая төгрөг буюу 5.7 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	196.1	508,403.2	508,207.1
Авлага	93.4	736.4	643.0
Бараа материал	9,897.5	16,803.4	6,905.9
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	260.7		(260.7)
Үндсэн хөрөнгө	119,018.0	218,649.5	99,631.5
Нийт хөрөнгө	129,465.7	744,592.5	615,126.8
Өр төлбөр	13,637.8	15,457.8	1,820.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	115,827.9	729,134.7	613,306.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	129,465.7	744,592.5	615,126.8

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, эздийн өмч данснууд байна.

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл нь 508.4 сая төгрөг болж, 508.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Эдийн засаг, хөгжлийн яамнаас авсан татаас, санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлээр өссөн;
- Авлага дансны үлдэгдэл 0.7 сая төгрөг болж, 0.6 сая төгрөгөөр өссөн нь ажиллагсадтай холбогдсон тооцооны авлагаар нэмэгдсэн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь 218.6 сая төгрөг болж, 99.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 47.8 сая төгрөгийн биет болон биет бус хөрөнгө худалдаж авч, ТӨБЗГ-ын 2025 оны 41 дүгээр тогтоолоор Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-аас 11.9 сая төгрөгийн, 749 дугаар тогтоолоор ЭЗХЯ-наас 101.8 сая

төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил үнэ төлбөргүй шилжүүлэн авч, 27.1 сая төгрөгийн шилжиж ирсэн үндсэн хөрөнгийн элэгдэл, 34.8 сая төгрөгийн тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулсантай холбоотой;

- Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 15.5 сая төгрөг болж, 1.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дансны өр төлбөр 1.5 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 0.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан;
- Эздийн өмч дансны үлдэгдэл 729.1 сая төгрөг болж 613.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн 613.3 сая төгрөгөөр нэмэгдсэн зэргээс тус тус шалтгаалжээ.

Судалгааны үр дүн: Тайлант онд 12.3 сая төгрөгөөр дотоод сүлжээний эрх, 4.4 сая байгууллагын цахим хуудас, нийт 16.7 сая төгрөгөөр биет бус хөрөнгө худалдаж авч программ хангамж биет бус хөрөнгөөр бүртгэсэн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ нь эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, ТӨБЗГ-аар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-ын захирлын 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/021 дүгээр тушаалаар “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-ын 2025 оны “Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г баталжээ.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/05 дугаар тушаалаар тус төвийн урсгал зардалд 10,330.3 сая төгрөгийн төсвийг зарцуулах эрхийг шилжүүлсэн ба 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2025 оны төсвийн нэмэлт өөрчлөлтөөр 5,557.4 сая төгрөгөөр бууруулж, 4,772.9 сая төгрөгөөр төсвийг тодотгон баталсан байна.

Гүйцэтгэлээр ЭЗХЯ-аас 2,228.0 сая төгрөгийн татаас, санхүүжилтийг авч, арилжааны банкнаас 11.8 сая төгрөгийн хүүгийн орлого, үйл ажиллагааны орлогоос 5.7 сая төгрөг, 86.7 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээж авсан үндсэн хөрөнгийг бусад орлогоор хүлээн зөвшөөрч, 1,717.1 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гаргаж, 613.3 сая төгрөгийн тайлант үеийн үр дүнтэй ажиллажээ.

Нийт зардлын гүйцэтгэл 1,717.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 3,055.8 сая төгрөгөөр дутуу зарцуулахад батлагдсан татаас, санхүүжилтийг 2,545.0 сая төгрөгөөр дутуу авч, 2,995.8 сая төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөрт сонгон шалгаруулалтаар шалгарсан төсөл хэрэгжүүлэх нэгжид олгох дэмжлэг олгоогүй нь нөлөөлжээ.

Бараа, ажил үйлчилгээ худалдан авах арга хэмжээнд 17 ажил төлөвлөснөөс 16 нэр төрлийн тоног төхөөрөмж, тавилга худалдан авахад 33.6 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант оны хуримтлагдсан үр дүн 613.3 сая төгрөг болсон нь төсвийн хэмнэлтээс шалтгаалжээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 7 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

1. Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар:

ТӨБЗГ-ын 2024 оны 428 дугаар тогтоолоор “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-ын бүтэц, орон тооны дээд хязгаар, албан тушаалын жагсаалт”-аар 25 орон тоотой үйл ажиллагаа явуулахаар тогтоожээ. Гүйцэтгэлээр 23 орон тоотой ажиллаж, өөрийн хүсэлтээр 2 албан хаагч ажлаас гарсанд шинээр ажилтан аваагүй байна. Цалин

хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 1,038.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 1,028.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:

Тус төвийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн А/20 дугаар тушаалаар нэг хүнд ногдох сард 180.0 мянган төгрөгийн хоол, унааны зардал олгохоор баталжээ. Тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын төсвийг 54.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 45.3 сая төгрөгийн зардалг гарагж, батлагдсан төсвийг 8.7 сая төгрөгөөр дутуу зарцуулжээ.

3. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн:

Тус төвийн захирлын 2025 оны тушаалуудаар 9 удаагийн дараахь сургалтад давхардсан тоогоор 110 албан хаагч хамрагдаж 32.5 сая төгрөг зарцуулжээ. Үүнд: Худалдан авах ажиллагааны АЗ, байгууллагын соёл, ажилтны хандлага харилцаа, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, капитал төсөвлөлт, түүний мөнгөн урсгалууд, мөнгөний үнэ цэнэ цахим арга зүйд сургах, үндэсний бичгийн цахим сургалт, байгууллагын 2026-2028 страгеги төлөвлгөө хэрэгжүүлэх, чадавхижуулах

4. Гадаад албан томилолтын зардлын талаар:

Тус төвийн захирлын 2025 оны тушаалаар удирдамж батлуулан 13 албан хаагч 5 удаагийн сургалтад хамрагдаж 69.8 сая төгрөгийн гадаад томилолтын зардал гарчээ. Үүнээс Сангийн сайдын 2011 оны А/188 дугаар тушаалаар шинэчлэн баталсан зардлын хэмжээг баримтлаагүй илүү олгосон гадаад албан томилолтын зардалд 8.6 сая төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээ талаар:

Өдрийн сонинд Хувийн хэвшил төрийг бодвол хурдан шуурхай, менежентийн хувьд дэвшилттэй ярилцлага, ЭЗХЯ-тай хамтран төр хувийн хэвшлийг сурталчлах форум зохион байгуулах, Рөүд Тек Сольюшин ХХК-аар төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн танилцуулга, контент, хиймэл оюун ухаан, төвийн төслийн үе шат, видео, реел контент бүтээх, төвийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төслийн талаар хиймэл оюун ухааныг ашиглан реел бүтээх зэрэг ажилд 25.8 сая төгрөг зарцуулсан байна.

6. Шүүхийн шийдвэрийг нөхөн төлүүлсэн зардал тайлант онд гараагүй байна.

7. Төрийн өмчит үйлдвэрийн газрын судалгааны талаар:

“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-ын төрийн эзэмшлийн 100 хувийг ТӨБЗГ эзэмшдэг, улсын бүртгэлийн гэрчилгээнд дүрмийн сан тусгагдаагүй, санхүүгийн тайланд төрийн өмчийн эзэмшлийн дүнгүй, ТӨБЗГ-аас тайлант оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг баталж өгөөгүй, харин тус төвийн захирал нь баталж, ашиг алдагдал, ногдол ашгийг төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааг сайжруулах, эд хөрөнгийн тооллого хийх, дансны өр авлагын тооцоо нийлэх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Цэгцтөв богд аудит” ХХК-ийн ахлах аудитор Д.Өлзий-Орших, туслах аудитор П.Пунцаг нар гүйцэтгэж, аудитын менежер Т.Энхцэцэг, захирал Н.Цэрэнханд нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Ариунжаргал, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ нь 2026 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 26/26 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 4,772.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 47.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу ТӨААТҮГ нь 2025 онд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж, төсөл сонгон шалгаруулалтаар шалгарсан байгууллагад олгох 2,995.7 сая төгрөгийн дэмжлэгээс бусад цалин хөлс болон нэмэгдэл урамшлийн зардлыг 9.3 сая төгрөгөөр, НДШ-ийн 0.4 сая төгрөгөөр, хангамжийн материалыг 4.4 сая төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 3.8 сая төгрөг, томилолтын зардлыг 5.2 сая төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлагыг 7.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг ажил үйлчилгээний төлбөрийг 5.4 сая төгрөгөөр нийт 36.0 сая төгрөгийн хэмнэлтийг гарган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 466.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст 66 мэдээлэл байршуулахаас 34 мэдээллийг хугацаа хоцроож, цалингийн бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 466.0 сая төгрөгийн зарлагын 28 мэдээллийг байршуулаагүй.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулах мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, мэдээлэх зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тус төвийн ерөнхий нягтлан бодогчийн сонгон шалгаруулалт болон ажлын байрны тодорхойлолтод мэргэшсэн нягтлан бодогч байх тусгай шаардлагыг тусгаагүйгээс мэргэшсэн нягтлан бодогчийн эрхгүй хүнийг Сангийн яамтай зөвшилцөөгүй томилсон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 3-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн байх бөгөөд түүнийг Сангийн яамны зөвшөөрөлтэйгээр захирал томилно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ерөнхий нягтлан бодогчийг хуульд заасан шаардлагад нийцүүлэн, ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулж, Сангийн яамны зөвшөөрөл авах зөвлөмж өгөв.

2. Тус төвийн нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тус ТӨААТҮГ-ын онцлогыг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн нөөц боломжоор төсвөөс зардал гаргахгүйгээр боловсруулан бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

3. Засгийн газрын 2024 оны 23 дугаар тогтоолоор ЭЗХЯ-ны харьяанд "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" ТӨААТҮГ-ыг байгуулж дүрмийг баталжээ. Тайлант онд үйл ажиллагаанаас орлого бүрдүүлэх төлбөр, хураамжийн хэмжээг эрх бүхий байгууллагаас батлаагүй, түншлэлийн төсөл хэрэгжээгүй зэргээс шалтгаалан тус газрын дүрэмд заасан өөрийгөө санхүүжүүлэх нөхцөл бүрдээгүй, улсын төсвөөс 100 хувийн санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-д "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ", Дүрмийн Зургаагийн 6.7.2-д "түншлэлийн төвийн үйл ажиллагаанаас орлого олох", Долоогийн 7.1-д "Түншлэлийн төвийн үйл ажиллагааны зардлыг өөрийн үйл ажиллагааны орлого, хууль, тогоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээр санхүүжүүлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааны орлого бүрдүүлэх төлбөр, хураамжийн хэмжээг эрх бүхий байгууллагаар тогтоолгож, өөрийгөө санхүүжүүлэх зарчмыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн.

4. Эд хариуцагчийн орон тоо байхгүйгээс шалтгаалан хяналт тавих үүрэгтэй нягтлан бодогч нь эд хариуцагчийн ажлыг хавсран гүйцэтгэсэн.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сохирхлыг зохицуулах, ашиг сохирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д "Албан тушаалтан албан үүрэгтэй нь шууд ба шууд бусаар холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг бусад этгээдийн өмнө төлөөлөхийг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 2-д "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна", 68 дугаар зүйлийн 1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бүртгэн авч хадгалах, түүнийг нэр төрөл, чанар, бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тавьж олгох, үүрэг бүхий этгээдийг эд хариуцагч гэнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТӨААТҮГ-ын эд хөрөнгийн анхан шатны бүртгэлийг хөтөлж, тайлан гаргадаг, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг хариуцах эд хариуцагчийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны III улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансдын хувьд горим сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 103.1 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 2,149.5 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, хэрэгжээгүй 8.6 сая төгрөгийн зөрчилд нөхөн төлүүлэх төлбөрийн актыг жилийн эцсийн аудитаар хүргүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус газрын үйл ажиллагаанаас орлого бүрдүүлэх төлбөр, хураамжийн хэмжээг эрх бүхий байгууллагаас батлаагүй, түншлэлийн төсөл хэрэгжээгүй зэргээс шалтгаалан орлого олох нөхцөл бүрдээгүй, өөрийгөө санхүүжүүлэх боломжгүй болж, ЭЗХЯ-ны татаас, санхүүжилтээр 2024, 2025 онуудад үйл ажиллагааны зардлыг 100 хувь санхүүжүүлж байгааг харгалзан аж ахуйн нэгжийн статусыг оновчтой тодорхой болгох шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 80.2 сая төгрөгийн 4 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулга хийлгэлээ. Үүнд:

Залруулсан алдаа:

- Тайлант оны түрээсийн төлбөрийн 39.9 сая төгрөг, ашиглалтын зардлын 3.5 сая төгрөг, нийт 43.4 сая төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгэж тайлагнасан;
- Хүүгийн орлогын албан татвар 1.2 сая төгрөг, бусад орлогын албан татварын 0.5 сая төгрөгийг орлогын татварын зардлаар тайлагнаагүй;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 34.8 сая төгрөгөөр илүү байгуулсан;
- Ажиллагсдад илүү олгосон 0.3 сая төгрөгийн дотоод албан томилолтын авлагыг тайланд тусгаагүй;

Эдгээр алдаанууд нь НББОУС-1 15 дугаар параграфт “санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга маань ажил гүйлгээ бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “ангилал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 91.9 сая төгрөгийн зөрчил² илэрсэнд 8.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 21.0 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 62.3 төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 91.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Сангийн сайдын 2011 оны А/188 дугаар тушаалаар шинэчлэн баталсан зардлын хэмжээг баримтлаагүй 8 албан хаагчид нийт 8.6 сая төгрөгөөр гадаад албан томилолтын зардлыг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2.4 “...Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно”, “Гадаад томилолтын зардлыг шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалд заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаад албан томилолтын зардлыг илүү олгосон 8.6 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисс нь хөрөнгийг тооллогыг хийхдээ Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан маягтаар тооллогын бүртгэл хөтлөөгүй, тооцоо бодсон акт үйлдээгүй зөвхөн тооллого хийсэн тайлан хавсаргасан, 16.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлд тооллогыг хуульд заасан хугацаанд хийгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4/ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх, 73 дугаар зүйлийн 2. "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6"эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийгээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Үндсэн хөрөнгөнд бүртгэлгүй 2 автомашины авто зогсоолын төлбөрт 640.0 мянган төгрөг (НӨАТ-н 10 хувь оруулаагүй) төлөхөөр түрээсийн гэрээ байгуулсан ч сар бүр 704.0 мянган төгрөг төлж, нийт 4,224.0 мянган төгрөгөөр байгууллагын төсвийг үрэлгэн зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3 "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

5.3 Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал:

Илрүүлэлт-1:

ТӨБЗГ-аар тайлант оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг батлуулаагүй, өмнөх оны цэвэр ашгийн дүнгээс тооцсон 57.9 сая төгрөгийн ноогдол ашгийг хуулийн дагуу тохиролцон тогтоолгоогүй, улсын төсвийн татаас санхүүжилтийн үлдэгдэл 45.7 сая төгрөгийг улсын төсөвт буцааж төвлөрүүлсэн зэргээс шалтгаалан ТӨБЗГ-ын 2025 оны 312 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх боломжгүй болсон.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг "төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох", 19 дүгээр зүйлийн 1-ийн 2/ "эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин", 20 дугаар зүйлийн 1-ийн 3/ "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ТӨБЗГ-т уг тогтоолыг хэрэгжүүлэх боломжгүй болсон нөхцөл байдлын талаар танилцуулж, асуудлыг шийдвэрлүүлэх, холбогдох хууль, тогтоомжийн дагуу эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг батлуулах.

2. Ажил гүйлгээтэй холбоотой асуудал

Илрүүлэлт-2:

Орон нутагт албан томилолтоор ажилласан 10 ажилтан олгосон 4.3 сая төгрөгийн томилолтын зардлыг цалингийн зардалд оруулан тайлагнаж, НДШ болон ХХОАТ-ыг суутган тооцсон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль, тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж, албан томилолтоос нийгмийн даатгалын шимтгэл болон хувь хүний орлогын албан татвар суутгахгүй, цалингийн зардалд тайлагнахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.	Тайлант хугацааны ашиглалтын зардлын нийт 43.4 сая төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгэж тайлагнасан.	1	43,400.0			1	43,400.0						
2.	Хүүгийн орлогын албан татвар 1.2 сая төгрөгийг, бусад орлогын албан татварын 0.5 сая төгрөгийг орлогын татварын зардлаар тайлагнаагүй.	1	1,753.9			1	1,753.9						
3.	Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг илүү байгуулсан.	1	34,789.7			1	34,789.7						
4.	Ажиллагсдад илүү олгосон дотоод албан томилолтын авлагыг тайланд тусгаагүй.	1	292.0	1	292.0								
	Дүн	4	80,235.6	1	292.0	3	79,943.6						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтан	Тоо	Дүн	
Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисс нь батлагдсан маягын дагуу тооллогын бүртгэл хөтлөөгүй, тооцоо бодсон акт үйлдээгүй, зөвхөн тооллого хийсэн тайлан хавсаргасан, 16.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй.	1	16,803.4			1	16,803.4							-
Сангийн сайдын 2011 оны А/188 дугаар тушаалаар шинэчлэн баталсан зардлын хэмжээг баримтлаагүй нийт 8.6 сая төгрөгөөр гадаад албан томилолтын зардлыг илүү олгосон.	1	8,582.5	1	8,582.5									-
Үндсэн хөрөнгөнд бүртгэлгүй 2 автомашины авто зогсоолын төлбөрт сар бүр 0.7 сая төгрөг төлж, нийт 4.2 сая төгрөгөөр байгууллагын төсвийг үрэлгэн зарцуулсан.	1	4,224.0			1	4,224.0							-
ТӨБЗГ-аар эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг батлуулаагүй, өмнөх оны цэвэр ашгийн дүнгээс тооцсон 57.9 сая төгрөгийн ноогдол ашгийг хуулийн дагуу тохиролцон тогтоогоогүй, татаас санхүүжилтийн үлдэгдэл 45.7 сая төгрөгийг улсын төсөвт буцааж төвлөрүүлсэн зэргээс шалтгаалан ТӨБЗГ-ын 2025 оны 312 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх боломжгүй болсон.	1	57,993.9					1	57,993.9					-
Албан томилолтоор ажилласан зарим ажилтанд олгосон 4.3 сая төгрөгийн томилолтын зардлыг цалингийн зардалд оруулж тайлагнасан.	1	4,310.0					1	4,310.0					-
Дүн	4	91,912.9	1	8,582.6	2	21,027.4	2	62,303.9	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны цахим хуудаст 66 мэдээлэл байршуулахаас 34 мэдээллийг хугацаа хоцроож, 466.0 сая төгрөгийн 28 мэдээллийг байршуулаагүй.	1	465,996.4			1	465,996.4
Дүн	1	465,996.4			1	465,996.4
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Тус төвийн ерөнхий нягтлан бодогчийн сонгон шалгаруулалт, ажлын байрны тодорхойлолтод мэргэшсэн нягтлан бодогч байх тусгай шаардлагыг тусгаагүйгээс мэргэшсэн нягтлан бодогчийн эрхгүй хүнийг Сангийн яамтай зөвшилцөөгүй томилсон.	1	-	-	-	1	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй, эрх бүхий албан тушаалтнаар батлуулаагүй.	1	-	-	-	1	-
"Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" ТӨААТҮГ-ын дүрэмд заасны дагуу түншлэлийн төсөл хэрэгжээгүй, үйл ажиллагаанаас орлого олох нөхцөл бүрдээгүй байна.	1	-	-	-	1	-
Эд хариуцагчийн орон тоо байхгүйгээс шалтгаалан хяналт тавих үүрэгтэй нягтлан бодогч нь давхар хариуцан гүйцэтгэсэн.	1	-	-	-	1	-
Дүн	4	-	-	-	4	-
Нийт дүн	5	465,996.4			5	465,996.4



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 154/А0150169

Улаанбаатар хот

САГ - 2026/65/НА - СТА - ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сангийн сайдын 2011 оны А/188 дугаар тушаалаар шинэчлэн баталсан зардлын хэмжээг баримтлалгүй 8 хүнд /хавсралтаар/ нийт 8,582,524.10 /найман сая таван зуун наян хоёр мянга таван зуун хорин дөрвөн төгрөг арван мөнгө/ төгрөгөөр гадаад албан томилолтын зардлыг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2.4-т "... Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно.", Сангийн сайдын "Гадаад томилолтын зардлыг шинэчлэн батлах тухай" 2011 оны 188 дугаар тушаалын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д " бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Гадаад албан томилолтын зардлын илүү олгосон 8,582,524.10 /найман сая таван зуун наян хоёр мянга таван зуун хорин дөрвөн төгрөг 10 мөнгө/ төгрөгийг "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" ТӨААТҮГ-ын захирал /М.Амгаланбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Энхтуяа/ нараар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ-ын захирал /М.Амгаланбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Энхтуяа/ нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Н.ЦЭРЭНХАНД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Aki-2026-0316-SAG-16.Docx

152600172



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 673/АД150169

Улаанбаатар хот

САГ-2026/65/НА - ЦТА-ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын 2025 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогын комисс нь үндсэн хөрөнгийг тоолохдоо Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан маягтаар тооллогын бүртгэл хөтлөөгүй, зөвхөн тооллого хийсэн тайлан хавсаргасан, 16,803,440.00 /арван зургаан сая найман зуун гурван мянга дөрвөн зуун дөчин/ төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй, хөрөнгийн тооцоог бодсон акт үйлдээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх", 73 дугаар зүйлийн 2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.2-д "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийгээгүй, баталсан маягтаар эд хөрөнгийн тооллогын бүртгэл хөтлөөгүй, тооцоо бодсон акт үйлдээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ-ын захирал /М.Амгаланбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Энхтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Н.ЦЭРЭНХАНД

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban Shaardlaga-2026/0316 SAG-25 Docx

1526180816



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 674/А0150169

Улаанбаатар хот

САГ - 2026/65/НА - СТА - ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлгүй 2 автомашины авто зогсоолын төлбөрт 640,000.00 /Зургаан зуун дөчин мянган/ төгрөг (НӨАТ-н 10 хувь оруулаагүй) төлөхөөр түрээсийн гэрээ байгуулсан боловч 6 сар 704,000.00 /долоон зуун дөрвөн мянган/ төгрөг төлж нийт 4,224,000.00 /дөрвөн сая хоёр зуун хорин дөрвөн мянган/ төгрөгөөр төсвийг үрэлгэн зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3 "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4-д "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ-ын захирал /М.Амгаланбаатар/, ерөнхий нягтлан бодогч /Б.Энхтуяа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭГЦТӨВ БОГД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Д.ЦЭРЭНХАНД